

**2019.07.08-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2019.07.08

№19

Дархан

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн	Хэрэгжилт
1	Техникийн комисс ажилласан гэж маргалдаад байгаа. Буянбат нь техникийн комисс биш гэх юм. Одгэрэл нь техникийн комисс мөн гэж маргаад байсан. Үнэхээр техникийн комиссын бичиг баримтын шаардлага хангаж байгаа юм уу?	ОНӨГ	<p>Хүүхдийн паркийн тоглоомонд Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах” журмын 2.3 дахь заалтын дагуу урьдчилсан үзлэгийг хийж, шаардлагатай баримт бичиг, актыг үйлдэж, зохих дүгнэлтийг гарган Улсын комисс ажиллуулах журмын дагуу ГХБХБГ-аас Улсын комиссыг ажиллуулсан.</p> <p>“Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн”-д суурилуулсан тоглоомуудыг 2019.07.10-ний өдөр Улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан.</p> <p>Тус тоглоомуудыг НААҮГ-ын балансад бүртгэх тухай тогтоолын төслийг 2019.07.17-ний ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлнэ.</p>
2	АТГ-аас өгсөн зөвлөмж бий. НБХ-тэй хамтраад сургуулийн түрээсийн гэрээний тендерийг зарлаж дуусгаарай.	ОНӨГ, НБХ	<p>Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулах талаар тус газраас Боловсрол соёл, урлагийн газарт 2019.05.30-ний өдрийн 395 тоот, 2019.06.25-ний өдрийн 476 тоот албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн. Сургуулиуд тендерүүдээ зарлаад эхэлсэн байна.</p>
3	Тендер зарладаг байгууллага гэж ойлгож байвал буруу. Бүртгэлийн дүн мэдээлэл огт танилцуулахгүй байна. Мэдээндээ оруулж байх. 39-р байрны урд талын моднуудыг тайрсан. Бүртгэл нь хийгдсэн юм уу? Хагас жилийн ажлуудыг дор дор нь бүртгээд явбал танайд амар байдаггүй юм уу?	ОНӨГ	<p>Нийтийн аж ахуйн үйлчилгээний газрын техникийн комиссын актыг /модны үнийг нэхэмжилсэн/ Цагаан зуун ХХК-д өгсөн байгаа. НААҮГ-аас бүртгэлээс хасуулах талаар албан бичиг ирүүлээгүй байна.</p>
4	“Нигүүлсэн зам” ХХК эмнэлгийн урд талын замыг хучиж байгаатай өчигдөр явж танилцлаа. Индүү нь айлынх, аспалт ачсан машинууд нь айлынх. Ажил хийж байгаа газруудаа	ХОХБТХ, ОНӨГ	<p>“Төгс цас” ХХК гүйцэтгэж байгаа болно. “Дархан хот байгуулалт, барилга захиалагч” ОНӨААТҮГ-аас хяналтыг хийж ажиллаж байгаа. Ажлын гүйцэтгэл нь 90 хувьтай байна.</p>

	чанараар нь эрэмбэлдэг баймаар байна. Түрээсийн техниктэй газрууд байна. Ийм газруудын ажил чанартай явагдах уу? Дархан хот байгуулалт, барилга захиалагч ОНӨААТҮГ-аас хяналт байхгүй байна. Ямар материалаар, яаж хучиж байгааг харж хянах шаардлагатай. Алдаа гарвал хэн нь хариуцлага хүлээх вэ? Анхаармаар байна.		
5	Цахилгаан, эрчим хүч хязгаарлах үедээ урьдчилаад хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлдэг болмоор байна. Мэдэгдэл өгөлгүйгээр дахиж хязгаарлалт хийхгүй байх	ЗА	1а байрны хажууд шугам хоолой засварлаж байсан компанийн буруутай үйл ажиллагаанаас болж цахилгаан эрчим хүч тасалдсан байсныг сэргээн засварласан.
6	Баяр наадмын өдрүүдийн цаг агаарын мэдээг авч мэдээллэх	МТА	Баяр наадмын үеэр 7 хоногийн цаг агаарын мэдээг цахим орчинд байршуулж наадамчин олонд цаг агаарын мэдээг цаг алдалгүй хүргэсэн болно.
7	Баяр наадмын үеэр мэдээллийг цаг алдалгүй бэлтгэж олон нийтэд сурталчилж таниулах. Мэдээ бэлтгэх газар, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах. Наадмын ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан бүртгэл удаашрах хандлагатай байгаа тул Юнителтэй ярьж сүлжээний асуудал дээр анхаарал хандуулах	МТА, НБХ	Юнителийн гэр интернет төхөөрөмжийг ашиглан төв цэнгэлдэх хүрээлэнгээс баяр наадмын үеэр шууд дамжуулалтыг хийхийн зэрэгцээ мэдээ мэдээллийг цаг алдалгүй наадамчин олонд хүргэн ажиллалаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> - 4 удаагийн шууд дамжуулалт - 8 видео мэдээ - 27 фото мэдээ бэлтгэн наадамчин олонд мэдээлжээ. Мөн аймгийн Засаг даргын баяр наадмын видео мэндчилгээ болон фостор бэлтгэн цахим орчинд байршуулсан байна.
8	Сэлэнгэ аймгийн Наадам дууссан. Иймд наадамчид, морь уяачид манай аймгийн Наадамд ирж оролцох төлөвтэй байна. Иймд бүртгэлийн ажилчдын тоог нэмэгдүүлэх, зай талбайг нэмэгдүүлэх, ачааллыг тооцож зохион байгуулалтыг өндөр түвшинд хийх шаардлагатай байна.	Баяр наадмын хороо	Анхаарч ажилласан боловч азарганы уралдаан дээр алдаа гарсан.
9	Баяр наадмын өдрүүдэд МХГ өндөр хэмжээнд ажиллах	ХОХБТХ	Баяр наадмын үеийн худалдаа үйлчилгээнд ноцтой зөрчил гараагүй.
10	QUEEN-ний үйлчилгээний цагийн хуваарийг 02.00 цаг хүртэл сунгасан зөвшөөрлийг эргэж харах шаардлагатай байна. Иргэдээс гомдол ихээр гарч байгаа. Ажлын хэсэг явуулж дуу намсгагч хийсэн	ХОХБТХ	Тухайн аж ахуйн нэгжийн удирдлага Засаг даргын орлогчтой уулзаж үйл ажиллагаандаа анхаарч ажиллах хүсэлт тавьсан. Тодорхой хугацааны дараа

	эсэхийг шалгуулах шаардлагатай байна. Хэрэв дуу намсгагч хийгээгүй бол зөрчлийн тухай хуулиар зөвшөөрлийг хүчингүй болгох		гомдол гарвал шууд цуцлах тухай мэдэгдсэн болно.
11	Үйлдвэрийн замыг нөхөх шаардлагатай. Осол, аваар гарах эрсдэл өндөр байна. Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-т үүрэг өгөөд уруудаж байгаа тал, өгсөж байгаа талын толгой руу гарахын яг өмнөх шургалсан хэсгийг эхний ээлжинд нөхөх шаардлагатай байна. Баяр наадмын үеэр замын хөдөлгөөн нэмэгдэнэ. Иймээс хаахгүйгээр нөхөлтийн ажлыг хий.	ХОХБТХ	Тус авто замыг засварлахад шаардагдах төсвийг гаргаж, асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтээ Зам, тээврийн хөгжлийн яам, Төслийн удирдах нэгж, Чайна гео инженеринг корпораци ХХК-д тус тус хүргүүлсэн болно.
12	9,10-ний өдрүүдэд Цагдаагийн газар өндөржүүлсэн байдалд ажиллах талаар чиглэл өгөх	ХЭЗХ	Олон улсын авто рали уралдааны бэлтгэл ажлыг хангах, хамгаалалтыг өндөржүүлсэн байдалд зохион байгуулах талаар үүрэг чиглэл өглөө.
13	7 дугаар сарын 16-ны өдрөөс эхлээд амралтуудаа авч эхлээрэй. Би 8 дугаар сарын 1-ний өдрөөс амрах тул эхний амарсан хүмүүс зөрөөд орохоор хуваариа тохируулаарай.	ТЗУХ	2019 оны 3 сарын 11-ний өдрийн 2-Б/17 дугаар тушаалаар аймгийн ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүдийн ээлжийн амралтын хуваарийг баталсан. Удирдлага, хэлтсийн дарга нараас ээлжийн амралтаа аваагүй дараах хүмүүс байна. Т.Ганболд П.Баярсайхан П.Батсүх Н.Цасчихэр Б.Болдбаатар Б.Золзаяа Одоо амарч байгаа болон амралтаа авсан: А.Түвшинбат Ч.Энхбат Л.Алтанчимэг Б.Жаргалсайхан Д.Жаргалсайхан
14	Дархан хот байгуулалт, барилга захиалагч ОНӨААТҮГ, Н.Батсайхан дээр анхаарал хандуулъя.	ХОХБТХ	“Дархан хот байгуулалт, барилга захиалагч” ОНӨААТҮГ нь 2019 оны Улсын төсөв болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудад гүйцэтгэлийн хяналт тавин ажиллаж байна. ХОХБТХ-т долоо хоног бүрийн мягмар гаригт Улсын төсөв болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлын явцын талаар тайланг танилцуулж, тулгамдаж байгаа асуудлаа хэлэлцэн шийдвэрлэж байна.
15	Нөхөөсийн ажил ямар явагдаж байгаа вэ? Мэдээлэл авъя.	ХОХБТХ	Төв замын нөхөөснүүд хийгдсэн байгаа. Нийт хийгдсэн

			нөхөөсний гүйцэтгэл 50 хувьтай байна.
16	Замын путкээ буулгаж авъя. Үндсэн хөрөнгөөс хасаарай. Хүмүүсээ албан ёсоор чөлөөлье. Энэ бол олон жил яригдсан асуудал. Олон улсын зам дагуу орон нутгийн пост ажиллах нь өөрөө хууль бус учраас буулгахаас өөр аргагүй.	ХОХБТХ	Үйл ажиллагааг нь зогсоосон.
17	Паркийн ажлыг 10-ний өдөр нээнэ. Хариуцсан ажилтныг нь ажлын байрны тодорхойлолттой болгож үүрэгжүүлэх шаардлагатай байна. Би өөрөө биечилж уулзсан. Отгонтөгс гээд хүн байгаа. Тэр хүн дээр АБТ хийгээд гарын үсэг зуруулж аваарай. Алдаа гарвал хэн нь хариуцлагаа хүлээх вэ? Үүрэгжүүлж байж хүмүүс хариуцлагаа ухамсарлаж ажилдаа сэтгэлтэй хандана шүү.	ХОХБТХ	“Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн” хүүхэд залуучуудын соёл амралтын цогцолборын тоглоомыг хариуцах ажилтны ажлын байрны тодорхойлолтыг гаргаж баталгаажуулсан.
18	Паркийн нээлтийн ажлыг 10-ний өдөр амжихгүй бол 11-ний өдөр хийх. НААҮГ-ын хүн хүч хүрэхгүй бол Дархан сум хамтарч оролцох. Нээлтэд шаардлагатай хөгжим, техникийг нь НҮА хариуцаж ажиллаарай. Олдохгүй бол нам дээр хөгжим, узель байгаа шүү.	ХОХБТХ, НААҮГ, НҮА	“Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн” хүүхэд залуучуудын соёл амралтын цогцолборын тоглоомыг ашиглалтад оруулах нээлтийг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр НААҮГ зохион байгуулж ажилласан.
19	Морь барианы газрын дээврийг янзалсан уу?	ЗА	Морь барианы газрын дээврийг Тохижилт үйлчилгээний ажлын хэсэг засварласан. /БСТГ-ын дарга Н.Батлав дээврийн төмрийн хэсгийг шинэчлэн засварласан. /
20	Хүүхдийн номын ордонд өгөх машины асуудлыг шийдвэрлэсэн үү?	НБХ	Солонгос улсын HYANDAI starex-0 авто машины суудал, төрөл, зориулалт, ангиллыг өөрчлөн ашиглах боломжгүй тул номын уншлага үйлчилгээнд тохирохуйц суудал, хүн тээврийн жижиг тээврийн жижиг микро автобусаар хангах тухай 2019.07.08-ны өдрийн 34 тоот албан бичгийг Хүүхдийн номын ордноос хүргүүлсэн. Асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг судалж байна.
21	Сургууийн үдийн цай хөтөлбөрийг дахин дахин хэллээ шүү. 9 сардаа амжихгүй бол та 2 хоёулаа хариуцлагаа хүлээгээрэй.	ОНӨГ, НБХ	Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулах талаар тус газраас Боловсрол соёл, урлагийн газарт 2019.05.30-ний өдрийн 395 тоот, 2019.06.25-ний өдрийн 476 тоот албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн. Сургуулиуд тендерүүдээ зарлаад эхэлсэн.

22	ИТХ-д оруулж буй материалуудыг дахин дахин шалгаж оруулдаг болмоор байна. Нягтлаагүй материал оруулдаг гээд хурал дээр асуудал яригдаад байгаа шүү.	ТЗУХ	Тойрох хуудсаар санал авдаг болохоор төлөвлөн ажиллаж байна.
23	Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдөөс ирүүлж буй саналуудад заавал хариу өгч хэвшмээр байна. Тоохгүй байна гэсэн гомдол гарсан.	ХОХБТХ	Одоогоор ИТХ-ын Төлөөлөгчдөөс ирсэн санал байхгүй байна. Цаашид анхаарч ажиллах болно.
24	7 дугаар сарын 9-ний өдрийн баярын хурлыг өндөр хэмжээнд зохион байгуулах. Тайз руу цэцэгтэй хүн гаргахгүй байх талаар арга хэмжээг эртнээс авах. Зохион байгуулалтын тал дээр Санхүү төрийн сангийн хэлтсээс хүн хүч нэмж авах. Танхимыг хүнтэй байх тал дээр онцгой анхаарахгүй бол сүүлдээ 20, 30-уулахнаа суугаад үлддэг шүү.	ТЗУХ, НБХ, СТХ	Баяр наадмыг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу албан хаагчид баярын хурлыг зохион байгуулсан.
25	7 дугаар сарын 9-ний орой Тохь цогцолборт зохион байгуулах арга хэмжээг сайтар бэлтгэх	НҮА	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу захиалгыг цуцалсан.
26	Маргааш буюу 7 дугаар сарын 9-ний өдөр баярын хурлын өмнө хэлтсийн дарга нарын хурлыг зохион байгуулах	ТЗУХ	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу гүйцэтгэлийг хангаж ажилласан.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Ц.БОЛОРТУУЛ